



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

Т О Г Т О О Л

1960 оны 7 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 296

Улаанбаатар
хот

Гадаадын мэрэгжилтнийг үйлчлэх товчооны тухай.

Б.Н.М.А. Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Гадаад орнуудаас уригдаж ирсэн мэрэгжилтэн нарыг үйлчлэх ажиллагааг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны дэргэдэх гадаадын мэрэгжилтнийг үйлчлэх товчоог 1960 оны 7 дугаар сарын 1-ээр тасалбар болгон, Гадаад орнуудтай эдийн засгийн талаар харилцах улсын хорооны харьяанд шилжүүлэн өгч, аж ахуйн тооцоотойгоор ажиллуулсугай.

2. Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н. БАГАА/ -д даалгах нь:

а/ уригдаж ирсэн мэрэгжилтэн нарт зориулсан орон сууц, эд хөгшлыг элэгдэл хорогдлын фондын хамт 1960 оны 7 дугаар сарын 1-ний балансаар шилжүүлсүгэй;

б/ гадаадын мэрэгжилтнийг үйлчлэх товчоонд хотын төсвөөс 1960 онд олгох төсвийн дотацыг батлагдсан төсвийн ёсоор санхүүжүүлсүгэй;

в/ мэрэгжилтний байрын цэвэр ба бохир ус, дулаацуулах системийн техникийн үйлчилгээг Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанаас нэгдсэн журмаар гүйцэтгэж байсугай;

г/ уригдаж ирсэн мэрэгжилтнүүдэд зориулан, нийтийн хоолны трестийн 7 дугаар гуанзыг гадаадын мэрэгжилтнийг үйлчлэх

товчоонд харьяалуулж, түүний үндсэн ба гүйлгээ хөрөнгийг
балансаар гүйлгээний нь төлөвлөгөөтэй хамт шилжүүлсүгэй.

3. Гадаадын мэрэгжилтнийг анх ирэхэд нь хүлээн авч байр-
луулах, буцахад нь уналга тээврийн билет авч өгөх зэрэг
ажлыг гадаадын мэрэгжилтнийг үйлчлэх товчооноос шууд хариуцан
гүйцэтгэж байсугай.

4. Зөвхөн гадаадын мэрэгжилтний үйлчилгээнд зориулан,
„Побед“ машин I, „ГАЗ-69“ машин I, „ГАЗ-63“ машин I,
„ПАЗ-652“ автобус I -ийг гадаадын мэрэгжилтнийг үйлчлэх
товчоонд хувиарлан олгохыг Улсын Төлөвлөгөөний Комисс
/н.РАГЧАА/-д даалгасугай.

5. Гадаадын мэрэгжилтнийг үйлчлэх товчооны дагаж мөрдөх
дүрмийг боловсруулж, батлахыг Гадаад орнуудтай эдийн
засгийн талаар харилцах улсын хороо /н. БАЛЖИД/-д даалгасугай.

6. Гадаадын мэрэгжилтнийг үйлчлэх товчооны орон тоо,
сарын цалингийн фондыг батлаж өхийг Улсын орон тооны комисст
даалгасугай.

Б.Н.М.А. Улсын Сайд нарын
Зөвлөлийн I-р орлогч дарга

МОЛОМЖАМЦ

Б.Н.М.А. Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
гаарын дарга

БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн
эрхлэгч

/ДАГВАДОРЖ/

